

ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД

ЭРДЭНИЙН ГОВЬ-2013 ЁСЛОЛ 2014.04.29



ШИЛДГИЙН ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-ХАСУ МЕГАВАТТ ХХК

Оюу Толгой уурхайн талбарт дулааны төв станцын ашиглалт засварыг хариуцаж ажилладаг. ISO9001 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны урт хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ ажлын нарийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна. Жилд 400 гагнуурын техникч, 50 гагнуурын инженер, 100 гаруй цахилгаанчин бэлтгэх мэргэжлийн сургалтын төвийг

Германтай хамтран байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Гадаадад 80 гаруй ажилтныг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Ажилтнууддаа байр худалдаж авахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Хөдөлмөр хамгааллын хувцас, цэвэр ус зэрэг бүтээгдэхүүнийг Өмнөговь аймгийн ханган нийлүүлэгчдээс худалдан авч байна.



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭГЧ-ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ БАМБАЙ ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны олон улсын OHSAS18001:2007 стандартыг нэвтрүүлсэн. Холбогдох бичиг баримт, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Тус компани 113 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ажилтнуудаа хангаж ажилласан.



ШИЛДЭГ ШИНЭ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-ХАНГУРД ХХК

Ханбогд сумын Хангүрд компани 2013 оноос Оюу Толгой уурхайд замын усжуулалт, хог зайлуулалт, бохир, цэвэр усны тээвэрлэлтийн үйлчилгээг тус тус үзүүлж байна. Тусгай зориулалтын 14 машинтай бөгөөд том оврын автомашины жолооч нарыг сургалтад хамруулж, мэргэжил дээшлүүлсэн. Ажилтнууддаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт байнга зохион байгуулдаг.



ХАНБОГДЫН ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-ӨГӨӨМӨР ГАВИЛУУД ХХК

Ханбогдын Өгөөмөр Гавилууд компани нь Баяжуулах үйлдвэрийн даралтат усан цэвэрлэгээний үйлчилгээ эрхэлдэг. Үйл ажиллагааны доголдолтой талыг илрүүлэх дотоод аудитын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Хөрсний бохирдлоос зайлсхийх зорилгоор дугуй засвар, машин байрлуулах талбай байгуулах тохижуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Гурван ажилтнаа хүнд машин механизмын операторын сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэхтэй болголоо. Ахмадууд, орон нутгийн уламжлалт арга хэмжээ, хүүхдийн уралдаан тэмцээнд 1.3 сая төгрөгийн хандив өгсөн.



ӨМНӨГОВИЙН ШИЛДЭГ ШИНЭ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-БУЯНТ ГАЛБА ХХК

Ханбумбат онгоцны буудлын цэвэрлэгээ үйлчилгээ, кофе шопын үйлчилгээ үзүүлдэг. Сургалтын байгууллагуудтай хамтран эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, харилцагчийн үйлчилгээний тал дээр ажилтнуудынхаа чадавхийг дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа байнга явуулдаг.



ӨМНӨГОВИЙН ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-ГОВИЙН АНИР ХХК

2013 онд найдвартай ажиллагааг хангах сервэрийн өрөөг засан тоноглож, сүлжээний мониторингийн системийг хэрэгжүүлсэн. Тус компани өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хөтөлбөр бий болгон хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хөтөлбөрийн хүрээнд “Ажлын байрны эрсдлийн удирдлага” хэсгийг бусад орон нутгийн компаниудтай хуваалцан ажиллаж байна. Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд олон төрлийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн.



АЖИЛТНУУДАА МЭРГЭШҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭГЧ ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-МЭЖОР ДРИЛЛИНГ ХХК

Нийт ажилтнуудын 92 хувь нь Монголчууд байгаа бөгөөд удирдах түвшний ажлыг Монгол ажилтнууд олноор гүйцэтгэж байна. Ахлах ажилтнуудыг манлайлал болон дагалдуулан сургах хөтөлбөрт хамруулсан. Монгол ажилтнуудаа Сингапурт гадаад хэлний сургалтад хамруулсан. Ажилтнуудаа мэргэшүүлэхийн тулд Монголын өрмийн холбоо, Механик инженерийн сургууль, Замын цагдаа болон Австралийн мэргэшсэн багш нартай хамтран ажилласан.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ЭРХЭМЛЭГЧ ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-МЕХЛОПАТ ХХК

Компанийн нийгмийн хариуцлагын стратегийн хүрээнд Уул уурхайн сургууль, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Боловсролыг дэмжих ТББ, Лотус хүүхдийн төв зэрэг байгууллагуудтай өргөнөөр хамтран ажилласан. Оюутны тэтгэлэгт болон дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, Булган аймгийн Хялганат суманд компьютерийн лаборатори болон номын сан тус тус байгуулжээ. Эко уутны төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажилласан байна. Инженер техникийн ажилтнуудаа Голланд, Хятад, Австрали зэрэг улсуудад суралцуулсан.



НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ САЙЖРУУЛАГЧ ШИЛДЭГ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ-SLS BEARINGS ХХК

Нийлүүлэгчдийн тоогоо 32-52 болтол нэмэгдүүлсэн. Тус компани АНУ-аас Монгол руу шууд тээвэрлэлт хийх шийдлийг хэрэгжүүлжээ. Монголын тээвэр зуучлалын компанитай хамтын ажиллагааг эхлүүлсэн байна. Агуулахын багтаамжийг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулсан. Үндэсний хоёр ажилтныг гадаадад сургалтад хамруулсан. Үндэсний “Мэргэн чадвар” компанийг чадавхжуулан хөгжүүлж, өөрийн гэрээт дистрибьютор болгосон. “Мэргэн чадвар” компани нь Ханбогд суманд агуулах барьж, нутгийн иргэдийг ажлын байраар хангаж байна.